



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 02 сарын 03 өдөр

Дугаар А/69

Булган сум

Булган сумын харьяалалгүй 500 ахмад
настнуудад хүндэтгэл үзүүлэх тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.21, 66 дугаар зүйлийн 66.1, Ахмад настны тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.5 дахь заалт, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөцийн хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2.1.6 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. XII жарны "Хөхөгчин могой жил"-ийн хаврын тэргүүн сарын шинийн нэгэн, цагаан сарын баярыг тохиолдуулан Булган сумын харьяалалгүй 500 ахмадуудад хүндэтгэл үзүүлэхэд шаардагдах зардлыг хавсралтаар баталсугай.

2. Зардлын 25,805,000 (хорин таван сая найман зуун таван мянга) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөцийн хөрөнгөөс санхүүжүүлэхийг Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Алтаншагай)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Д.ПҮРЭВ-ОЧИР

Аймгийн Засаг даргын 2025 оны
02 дугаар сарын 03-ны ний өдрийн 4/27 дүгээр
захирамжийн хавсралт

АХМАД НАСТНУУДАД ХҮНДЭТГЭЛ
ҮЗҮҮЛЭХЭД ШААРДАГДАХ ЗАРДАЛ

д/д	Зардлын төрөл	Тоо, хэмжээ	Нэг бүрийн үнэ	Бүгд
1	2	3	4	5
1.	Гарын бэлэг	500 ш	40,000	20,000,000
2.	Чихэр	500 кг	10,000	5,000,000
3.	Тавгийн идээ бэлтгэх хэвийн боов	45 ш	9,000	405,000
4.	Тавгийн чихэр	5 кг	20,000	100,000
5.	Ном хурах зардал	2 хүн	50,000	100,000
6.	Тайз зөөх шатахууны зардал			200,000
	Дүн			25,805,000